



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/47

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.3, 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Сумын 2022 оны төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2022 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Шууд худалдан авалтын ажлын гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн дарга: (Засаг даргын Тамгын газрын дарга)
- Нарийн бичгийн дарга: (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)
- Гишүүд: (Ашиглагч байгууллагын төлөөлөл)
(Төрийн байгууллагын төлөөлөл)
(Иргэний төлөөлөл)

2. Худалдан авах ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг /Ажлын хэсгийн дарга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА П.ГАНЧИМЭГ

